

Мэс заслын вакуум өрөө болгох ажил нь доорх өрөө болон хэсгүүдийг шинээр төлөвлөж засварлахаас бүрэлдэнэ.

- Мэс заслын вакуум хагалгааны өрөө 3 ширхэг,
- Мэс заслын дараах сэрээх өрөө 6-н ортой,
- Эрчимт эмчилгээний 8-н ортой өрөө 160м² багагүй,
- Анхдагч багаж, хэрэгсэл угаах өрөө,
- Эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөө,
- Эрэгтэй, эмэгтэй хувцас солих өрөө,
- Эрэгтэй, эмэгтэй душ,
- Цэврийн бүсрүү нэвтрэх хэсэг,
- Гутал солих хэсэг,
- Эм тариа бэлтгэх өрөө,
- Бохир хадгалах өрөө,
- Өвчтөний ар гэрийхэнтэй уулзах өрөө,
- Тоног төхөөрөмжийн техникийн өрөө зэрэг өрөөнүүдээс бүрдэнэ.

Вакуум мэс заслын өрөөнд тавигдах олон улсын стандарт шаардлагыг хангасан тоног төхөөрөмж материалаар ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

- ❖ Шинээр хийх хагалгааны өрөөнүүдийн хийн системийг эмнэлгийн хийн системтэй холбох
- ❖ Агааржуулалтын тоног төхөөрөмжийн өрөөг байрлуулах тохиромжтой байршлыг сонгож, мэс заслын өрөөтэй холбох шийдлийг гаргах
- ❖ Мэс заслын өрөө болон цэврийн коридорын хаалгыг автомат хаалгаар, техникийн өрөө болон бусад өрөөнүүдийн хаалгыг мэс заслын өрөөний зориулалтын ган хаалгаар хийсэн байх.

Тавигдах үндсэн шаардлага.

№	Гүйцэтгэх ажил	Тавигдах шаардлага	Тоо ширхэг
	Агаар боловсруулах тоног төхөөрөмж угсрах /АНУ/	Агаар цэвэршүүлэх, агаар халаах, агаар хөргөх, агаар чийгшүүлэх, агаар ариутгах үйлдлийг нэг дор хийх боломжтой; автомат компьютер хяналтын системтэй, агаарын автомат тохируулгын хаалтуудтай, өгөх буцах агаарын шугам хоолойтой холбогдсон байх. Агаар цэвэршүүлэх хүчин чадал 5000м ³ /цаг доошгүй, хөдөлгүүрийн хүчин чадал 4kW-аас доошгүй; хөргөлтийн хүчин чадал 12kW доошгүй, шинэ агаар халаах хүчин чадал 8kW, үндсэн цахилгаанаар халаах хүчин чадал 15kW-аас доошгүй, агаар чийгшүүлэх хүчин чадал 15кг/цаг дээш, чийгшүүлэгчийн халаагуурын хүчин чадал 11kW-аас доошгүй; цахилгаан эрчим хүч 380вольт, зэс хоолойгоор гаднах хөргөлтийн тоног төхөөрөмжтэй холбогдсон байх. Хэмжээ 3800x900x1100мм багагүй, жин 890кг ихгүй, Үйлдвэрлэсэн он 2019, 2020 байх,	3
	PLC компьютер систем угсрах	Орчин үеийн хяналтын программ суурилуулах Процессорын хурд SR30 Шуурхай санах ой DR08 багагүй хүчин чадалтай	3
	Мэс заслын өрөөнд Нера Filter суурилуулах	Н-14 доошгүй хүчин чадал бүхий 99,99 хувь доошгүй агаарыг шүүх хүчин чадалтай	Тооцооллоор
	Зориулалтын металл хавтангаар мэс заслын өрөөний хана хийх /Clean Room Panel/	1,2мм доошгүй зузаантай металл гадаргуутай зориулалтын тоосжилт үүсдэггүй, бактер хуримтлагдах, үржих боломжгүй гадаргуутай, арчиж цэвэрлэхэд хялбар, гипсэн хавтан хүчитгэлтэй Clean Room Panel хавтангаар хана хийх.	Тооцооллоор
	Зориулалтын металл хавтангаар мэс заслын өрөөний тааз хийх /Clean Room Panel/	1,2мм доошгүй зузаантай металл гадаргуутай зориулалтын тоосжилт үүсдэггүй, бактер хуримтлагдах, үржих боломжгүй гадаргуутай, арчиж цэвэрлэхэд хялбар, гипсэн хавтан хүчитгэлтэй Clean Room Panel хавтангаар хана хийх.	Тооцооллоор
	Мэс заслын хэсгийн бусад хана, таазыг хийх	4мм-ээс доошгүй зузаантай металл гадаргуутай зориулалтын тоосжилт үүсдэггүй, бактер хуримтлагдаж, үржих боломжгүй, гадаргуутай, арчиж цэвэрлэхэд хялбар Clean Room Panel-хавтангаар хана тааз хийнэ.	Тооцооллоор
	Тэгш өнцөгт огтлолтой агаар дамжуулах, агаар өгөх буцах шугам хоолой угсрах	Булан, мувьт, троник, гуравлагч, дөрөвлөгч болон хийцлэлтэй хэсэгт 0,6мм доошгүй, 1,2м ээс урт хэсэгт 0,7мм багагүй хуудсан гангаар тэгш	Тооцооллоор

		өнцөгт огтлолтой салхивчийн хоолой хийж гүйцэтгэнэ. Галд тэсвэртэй, эрүүл ахуй аюулгүй ажиллагааны шаардлага хангасан 20мм зузаан Rubber материалаар дулаалсан 30х30мм булан төмрөөр фланец угсарч өгөх буцах шугам хоолойнууд хийсэн байх. Агаарын шугам хоолойнд дуу намсгагч, агаарын хаалтуудыг тооцооллоор угсрах.	
	Удирдлагын самбар угсрах (Агаар боловсруулах төхөөрөмжийн тохиргооны самбар)	Мэс заслын эхлэх дуусах цаг, орон нутгийн цаг гардаг, өрөөний температур, чийгшил, хийн заалтыг харах боломжтой байх.	3
	Мэс заслын өрөөнд норкозын багаж хэрэгсэл, эм тариа хадгалах шүүгээ угсрах	Мэс заслын өрөөний зориулалтын, зэвэрдэггүй 1мм зузаантай ган материалаар хийсэн, нүдэнд харагдахгүй аргаар гагнасан, арчиж цэвэрлэхэд хялбар, 4-ээс доошгүй тавиуртай, цоожтой шургуулгатай байх. Хэмжээ 900ммх1500ммх250мм багагүй. Хананд ухаж суулгасан байх.	3
	Мэс заслын багаж хэрэгсэл хадгалах шүүгээ	Мэс заслын өрөөний зориулалтын, зэвэрдэггүй 1мм зузаантай ган материалаар хийсэн, нүдэнд харагдахгүй аргаар гагнасан, арчиж цэвэрлэхэд хялбар, 4-ээс доошгүй шилэн тавиуртай байх. Хэмжээ 900ммх1500ммх250мм багагүй. Хананд ухаж суулгасан байх.	3
	Эм тариа, ороох боох материал хадгалах шүүгээ угсрах	Мэс заслын өрөөний зориулалтын, зэвэрдэггүй 1мм зузаантай ган материалаар хийсэн, нүдэнд харагдахгүй аргаар гагнасан, арчиж цэвэрлэхэд хялбар, 4-ээс доошгүй шилэн тавиуртай байх. Хэмжээ 900ммх1500ммх250мм багагүй. Хананд ухаж суулгасан байх.	3
	Мэс заслын өрөөнд тэмдэглэл хөтлөх эвхэгддэг тавцан суурилуулах	Мэс заслын өрөөний зориулалтын, зэвэрдэггүй 1мм зузаантай ган материалаар хийсэн, нүдэнд харагдахгүй аргаар гагнасан, арчиж цэвэрлэхэд хялбар. Хэмжээ 400ммх600ммх250мм багагүй. Хананд ухаж суулгасан байх.	3
	Рентген хальс харах гэрлийн самбар суурилуулах	Мэс заслын өрөөний зориулалтын, 4-оос доошгүй стандарт хальс нэгэн зэрэг байрлуулж харах боломжтой. Хананд ухаж суулгасан байх	3
	Мэс заслын автомат гар угаагуур суурилуулах	3-аас доошгүй хүн нэгэн зэрэг угаах боломжтой, автомат хүний гарын оролцоогүй ус нээгдэж хаагддаг зэвэрдэггүй ган материалаар хийгдсэн, арчиж цэвэрлэхэд хялбар гар угаагуур суурилуулах. Хэмжээ 1800х1500х700мм Багагүй байх. Тольтой, гэрэлтэй байх.	Хүртээмжээр
	Мэс заслын өрөөнд автомат хаалга угсрах	Хөл мэдрэгчтэй 1,2мм багагүй зузаан гангаар хийсэн автомат хаалга угсрах, 1400мм*2000мм багагүй хэмжээтэй. Мэс заслын өрөөний зориулалттай. Шилэн цонхтой байх.	4

	Цэврийн бүсэд автомат хаалга угсрах	Хөл мэдрэгчтэй 1,2мм багагүй зузаан гангаар хийсэн автомат хаалга угсрах, 1400мм*2000мм багагүй хэмжээтэй. Мэс заслын өрөөний зориулалттай. Шилэн цонхтой байх.	3
	Цэвэр орчинд зориулагдсан ган хаалга	Бактерийн эсрэг хамгаалалттай 1,2мм зузаан гангаар хийсэн нэг хавтастай ган хаалга хэмжээ 900мм*2100мм	22
	Мэс заслын өрөөнд шаардлагатай газруудад 220; 380 Вольтын, газардуулгатай цахилгааны розетка угсрах	Мэс заслын өрөөний зориулалтын, зэвэрдэггүй 1мм зузаантай ган материалаар хийсэн, нүдэнд харагдахгүй аргаар гагнасан, арчиж цэвэрлэхэд хялбар. Хананд ухаж суулгасан байх, нэг мэс заслын өрөөнд 6 доошгүй ишнүүр залгаж хүрэлцэхүйц байх олон тусмаа давуу тал болно.	9
	Гэрэлтүүлэг LED.	Мэс заслын өрөө болон туслах өрөөнүүдэд тусгай Clean Room зориулалтын туслах LED гэрлүүд суурилуулах	тооцооллоор
	Тусгай эмнэлгийн зориулалтын хулдаасан шал хийх /Gerflor/.	2мм багагүй зузаантай, вакуум хагалгааны өрөөний зориулалттай, цул бүтэцтэй, цахилгаанждаггүй байх ба залгааг гагнаж наана.	Тооцооллоор
	Мэс заслын өрөөний хананд эмнэлгийн хийн хангамжийн холболтын консоль системийн самбар угсрах.	4-н төрлийн хийн DIN стандартын хошуу орох холболттой мономерт хэмжигчтэй байх. Мэс заслын өрөөний зориулалтын, зэвэрдэггүй 1мм зузаантай ган материалаар хийсэн, нүдэнд харагдахгүй аргаар гагнасан, арчиж цэвэрлэхэд хялбар. Хананд ухаж суулгасан байх. Хүчил төрөгч, агаар, нүүрс төрөгч, азот, вакуум зэрэг 5 төрлийн герман стандартын DIN хошуугаар холбогдох боломжтой. Тус төхөөрөмжийг эмнэлгийн хийн системтэй зэс хоолойгоор гагнаж холбох.	3
	Сэрээх өрөөний орны толгойн консоль систем	2-оос доошгүй төрлийн хийн DIN стандартын хошуу орох холболттой, 220вольтын разетка суурилуулсан байх, сувилагч дуудах калл систем байрлуулах.	14
	Агаар чийгшүүлэгч төхөөрөмж	Чийгшүүлэх хүчин чадал 15кг/цаг доошгүй, Халаагуурын хүчин чадал 11,3kW багагүй.	3
	Температур ба чийгшил мэдрэгч	Агаарын даралт, температур, чийгшилын тоон мэдээлэл дамжуулах	тооцооллоор
	Таазанд суурилагдсан дүүжин тоног төхөөрөмж Ceiling Pendant	Хийн холболтын тоо 3 доошгүй Даралт даах чадвар 30kPa~80.0kPa багагүй Илүүдэл агаар гаргагчийн тоо 1 Интернет холболт 1	3

		<p>Телефон холболтын тоо 1 Цахилгаан разетканы тоо 3 10А Цахилгаан эрчим хүч АС220вольт+-22вольт 50Hz+-1Hz Тавиурын тоо 1 Шүүгээний тоо 1 Хэмжээ 200Х300Х180мм Эргэх өнцөг 270ө</p>	
	Шинэ агаар оруулах сэнс	<p>Агаар сорох хүчин чадал 1500м3/цаг багагүй, Хөдөлгүүрийн хүчин чадал 0,25kW багагүй, Хөдөлгүүрийн эргэлтийн тоо 1450об/минутаас их, Агаарын даралт 295Pa Хэмжээ тооцооллоор</p>	3
	Дусал хийх тарианы суурь	<p>0.8м-аас 1.35метр хүртэл сунгах өвчтөн, эмч, сувилагч нарын хэрэгцээнд хүртээмжтэй байх. Салган авах болон шилжүүлхэд хялбар байх.</p>	Хүртээмжээр
	Дижитал дэлгэц	<p>Тоног төхөөрөмжийн цахилгаан хэлбэлзлийг харуулах дижитал дэлгэцтэй байх</p>	3